

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН” 2023 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-005092
Регистрийн дугаар: 3863689*

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГазрын мэргэжилтэн:Б.Буяннэмэх

Төв аймгийн БОАЖГазрын мэргэжилтэн:С.Эрдэнэцогт

Биелэлтийг тайлагнасан:

“Заамар өгөөмөр хайрхан” ХХК-ийн захирал:..... Ч.Уламбаяр

“Заамар өгөөмөр хайрхан” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн:.....А.Дүүрэнбаяр

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Гарчиг

1. ОРШИЛ	4
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	6
3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	6
3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	6
3.3. Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	8
3.4. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд	8
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
8. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	12
11. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ.....	13
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 14	
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
14. ДҮГНЭЛТ	15

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Зургийн жагсаалт

Зураг 1 Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг	5
Зураг 2 Ажилчдын хотхон.....	7
Зураг 3 Цэвэр ба бохирын нуурнаас дээж авч буй байдал.....	8
Зураг 4 Агаарын тоосжилт хэмжилт хийж байгаа байдал	8
Зураг 5 Талбайд мод тарьж байгаа нь	9
Зураг 6 Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай.....	10
Зураг 7 Дүйцүүлэн хамгаалахаар техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай.....	11
Зураг 8 Ажилчдын хотхон, засварын талбайгаас хөрсний дээж авч байна	12
Зураг 9 Хөрсний дээж авч буй байдал.....	14
Зураг 10 Сургалтын явц.....	14

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол /MV-005092/	4
Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	6
Хүснэгт 3 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	6
Хүснэгт 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	8
Хүснэгт 5 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	8
Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт	11
Хүснэгт 7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт	14

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1 Ус ашиглах зөвшөөрөл.....	17
Хавсралт 2 Гүний худгийн усны дээж шинжилгээ MNS 0900:2018	168
Хавсралт 3 Технологийн усны дээж шинжилгээний дүн	19
Хавсралт 4 Ус ашиглах гэрээ	21
Хавсралт 5 Усны төлбөр төлсөн баримт	24
Хавсралт 6 Газар ашиглалтын гэрээ	25
Хавсралт 7 Газрын төлбөр төлсөн баримт	27
Хавсралт 8 БО –ны нөхөн сэргээлтийн барьцаа 50% төлсөн баримт.....	29
Хавсралт 9 Засварын талбай дахь хөрсний дээжний шинжилгээний дүн	30
Хавсралт 10 Уурхайн хотхоны хөрсний дээж шинжилгээний дүн	31
Хавсралт 11 Шимт хөрсний дээж шинжилгээний дүн	32
Хавсралт 12 Агаарын дээжний шинжилгээний дүн	33
Хавсралт 13 Хог хаягдлын гэрээ.....	32
Хавсралт 14 Хог хаягдлын төлбөр төлсөн баримт	35
Хавсралт 15 ТЭЗҮ хүлээж авсан тушаал, дүгнэлт	36

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ОРШИЛ

Манай компани нь байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн унаган төрхийг аль болох хадгалах, биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу өндөр түвшинд хийж гүйцэтгэх бодлого баримталж, байгаль орчны бодлого зорилтод нийцсэн арга хэмжээнүүдийг авч, биелэлтийг ханган ажилладаг. Үүнд:

- ★ Байгаль орчны бохирдолтоос сэргийлэх, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авах зорилгоор байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хийлгүүлэх
- ★ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомж холбогдох дүрэм журам стандартыг дагаж ажиллах
- ★ Олборлолт болон уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг тусган хэрэгжүүлэх хамаарна.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь тус оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний заалтуудыг ханган ажиллахад чиглэсэн болно.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Баянголын дэнж нэртэй MV-005092 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 200 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойш 20 км, “Шижир алт” суурингаас 15 км зайд, байр зүйн зургийн М-48-138 нэрэлбэрт орших ба талбайн булангийн цэгүүдийн газар зүйн солбилцолыг хүснэгтээр үзүүлэв. Бүс нутгийн хувьд Хэнтийн нурууны баруун хойд хэсэгт, Заамарын нуруу, Туул голын ай сав газарт, дэд бүтцийн тааламжтай нөхцөлд байрладагаараа онцлогтой.

Хар, хар хүрэн ойн үнсэнцэр хөрстэй, талбай орчмын хөрсөн бүрхэвч уулын хүрэн шороон хөрсийг карбонаттай, хархүрэн, хүрэн, цайвар, нугархаг хэмээн таван дэд хэв шинжид ангилдаг. Талбай орчмын хөрс нь хархүрэн ангилалд хамаарч байгаа юм. Ургамлын байгалийн бүс бүслүүрийн ангиллын хувьд Заамар сумын нутаг нь цөлийн хээр, өндөр уулын, уулын ойт хээр, уулын хээр, бэлчээрийн бус, хээр ба хуурай хээр гэсэн ангилалд хамаарна.


Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол /MY-005092/

Д/д	Уртраг	Өргөрөг
1	104° 30' 32.42"	48° 21' 19.32"
2	104° 30' 32.61"	48° 21' 16.71"
3	104° 30' 30.50"	48° 21' 17.48"
4	104° 29' 43.87"	48° 21' 10.62"
5	104° 29' 47.87"	48° 21' 08.86"
6	104° 29' 40.56"	48° 21' 0.15"
7	104° 29' 46.92"	48° 20' 57.36"
8	104° 29' 53.10"	48° 20' 46.06"
9	104° 29' 36.07"	48° 20' 46.06"
10	104° 29' 36.07"	48° 21' 00.91"
11	104° 29' 36.58"	48° 21' 00.91"

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

12	104° 29' 36.58"	48° 21' 8.09"
13	104° 29' 36.07"	48° 21' 08.09"
14	104° 29' 36.07"	48° 21' 15.73"
15	104° 29' 49.64"	48° 21' 15.99"
16	104° 29' 50.05"	48° 21' 21.53"

Зураг 1 Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн байршилн зураг



Зураг 2 Ажилчдын хотхон орчмын төлөв байдал



**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Заамар өгөөмөр хайрхан” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй.

3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос маслыг тогтоосон хугацаанд нь солих	Уулын мастер	250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн тос, маслыг сольж байсан.
2.	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол услах	Уулын мастер	Зам усалгааны ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байсан.
3.	Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлэх	Уурхайн дарга	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг хийлгэсэн ба шинжилгээний дүнг хавсаргав.
4.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө.	Уурхайн дарга	Тээврийн хэрэгслийн төлбөр, татварыг бүрэн төлж ажилласан.

3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Усны нөөцийг хамгаалах үүднээс технологит ашиглах усны хэмжээг бага байлгах үүднээс анхаарч ажилласан. Баяжуулах буюу элстэй шороог угаахад хэрэглэж буй усыг 30%-ийг сэлбэн 70%-ийг эргүүлэн ашигласан.

Хүснэгт 3 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Сав газартай гэрээ байгуулан ус ашиглах дүгнэлт гаргуулах	Компаний захирал	Сав газартай байгуулсан гэрээ болон ус ашигласан төлбөр төлсөн баримтаа хавсаргав.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2. Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх

3. Унд ахуйн усанд эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахин ажиллах

4. Уурхайн унд ахуйд хэрэглэж буй худагт тоолуур тавих

Байгаль орчны
мэргэжилтэн

Байгаль орчны
мэргэжилтэн


Шинжилгээний хариу шалгуур үзүүлэлт нь хавсралтад тусгагдав.

Бүсэд мөрдөх журмыг боловсруулан, нийт ажилчдад танилцуулсан.

Унд ахуйд хэрэглэж буй уст цэгтээ тоолуурж тавьж, орон нутгийн байгаль орчны байцаагчаар акт үйлдүүлэн баталгаажуулан ажилласан.



Зураг 3 Цэвэр, бохирын нуурнаас дээж авч буй байдал



Зураг 4 Агаарын тоосжилт хэмжилт хийж байгаа байдал

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3.3. Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

Хүснэгт 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Газар эзэмших гэрээгээ Заамар сумын 3Д-тай байгуулах, төлбөрөө төлөх	Компанийн захирал	Гэрээ болон төлбөр төлсөн баримтаа хавсаргав.
2.	6.8 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийх	Байгаль орчны мэргэжилтэн, уулын мастер	Нөхөн сэргээлтээ сум орон нутагт хүлээлгэн өгсөн тухай акт хавсаргав.
3.	Хуулсан шимт хөрсийг хадгалж хамгаалах	Байгаль орчны мэргэжилтэн	Шимт хөрсийг хэлбэршүүлэн хадгалсан бөгөөд 2023 онд шимт хөрсийг ашиглах учраас ургамалжуулах ажил хийгдээгүй.
4.	Засварын газраас өөр газарт тос, масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж, саармагжуулан бохирдсон хөрсийг авч зайлуулах	Байгаль орчны мэргэжилтэн	Засварын талбайгаас өөр газарт тос, масло асгарсан тохиолдол бүртгэгдээгүй ба саармагжуулах бүтээгдэхүүнүүд бэлэн байгаа билээ.
5.	Тоног төхөөрөмжийн тос масло солих газрын хөрсийг хамгаалах	Байгаль орчны мэргэжилтэн	Хамгаалах талбайг бэлтгэн, асгаралтын үед шаардагдах элс, шингээгч материалуудыг ойр байршуулсан.

3.4. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд

Хүснэгт 5 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	Өглөө бүрийн ажлын зааварчилгаанд заавар өгдөг. Уурхайн бүсэд мөрдөх байгаль орчны 7 дүрэм, зарчмыг боловсруулан, даган мөрдүүлэх тал дээр ажиллаж байна.
2.	Нөхөн сэргээлт хийсэн талбайд ургамлын бичиглэл хийнэ.	Байгаль орчны мэргэжилтэн	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайдаа ургамлын бичиглэлийг хийсэн.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

- | | | |
|--|----------------------|--|
| 3. Цөлжилтөөс хамгаалах ойн тухай
хуулийн дагуу уурхайн
ашиглалтын талбайд тарьсан
модоо арчлах хамгаалах | Компанийн
захирал | Өвлийг давж чадаагүй суулгацуудыг
хаяж, эрүүл ургаж буй модоо арчлан
хамгаалсан. |
|--|----------------------|--|

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны уулын ажлын төлөвлөгөөний **1.6 га** талбайд уулын ажил явагдахаар төлөвлөөд байсан бол **0.5 га** орчим талбайд уулын ажил явагдсан. Уурхайн ашиглалтын ажил явагдаж байхад нөхөн сэргээлт буюу дүүргэлтийн ажлыг дотоод овоолгоор зэрэгцээ байдлаар хийдэг. Энэ нь нөхөн сэргээлтийн зардлыг багасгах болоод их хэмжээний гадаад овоолгыг үүсгэн, газрын эвдрэл үүсгэхгүй байх давуу талтай.

Дотоод овоолгоор олборлолт явуулсан талбайн **2.5 га**-д техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд байсан бол **1.5 га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.

Биологийн нөхөн сэргээлтийг **2022 оны** Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй **2023** оноос хийхээр төлөвлөөд байна.

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төслийн талбайд тусгайлан мод үржүүлгийн суулгацын талбай бэлдсэн. Энэ талбайд одоогоор чацаргана 50ш, хайлаас 40ш, улиас 150, бургас 200ш, үхэр нүд 20ш суулгацыг үржүүлж байна.

2023 оноос орон нутагийн санал болгосон талбайд шилжүүлсэн суулгана.



Зураг 5 Үржүүлгийн талбайд ургаж байгаа мод

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, дэмжих зарчим баримтлан ажиллах үүрэгтэй.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орон нутгаас санал болгосон 15.0 га-д дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлтийг хийж хүлээлгэж өгсөн.



Зураг 6 Дүйцүүлэн хамгаалахаар техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай

**5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй.

**6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны олборлолтын явцад төслийн талбайгаас ямар нэгэн археологи, палеонтологийн дурсгал илэрч олдоогүй.

ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 онд осол эрсдэлгүй ажилласан байна. Ажилчдын дунд “Тэг Осол эрсдэлгүй ажлын байр” нэртэй уралдааныг сар бүр зохион байгуулж байгаа бөгөөд ажлын хэсэг тус бүрээс шилдэг ажилчдыг урамшуулдаг. Хөдөлмөр аюулгүй байдлын сургалт, өдөр тутмын зааварчилгааг ХАБ хариуцсан мэргэжилтэн өгч байгаа билээ.

Хүснэгт 6 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Нийт зардал (төг/жил)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Аянга цахилгаан	ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх.	Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулга хийхээс гадна, аянга зайлуулагч зэргийг онц шаардлагатай хэсгүүдэд байршуулсан	Хөрөнгө оруулалтын зардалд тусгагдана	Үйл ажиллагааны туршид	Галын аюулгүй байдлын тухай хууль, Ой хээрийн түймрээс хамгаалах тухай, Тусгай

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Гал түймэр	Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллагсад сургалт зохион байгуулах. Галын аюулын талаар анхааруулга самбарыг эзэмшлийн объект бүрд онцлогийг нь тусган тавих зэрэг арга хэмжээг авах шаардлагатай. Ой хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг үйлчлүүлэгчдэд анхааруулах, нэгэнт гарсан тохиолдолд холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэж, гал түймрийг богино хугацаанд унтраах аргыг үйлчилгээний ажилтнуудад эзэмшүүлэх	Гал гарч болзошгүй гэх бүх цэгүүдэд гал унтраах багаж хэрэгслүүдээр хангаж тэмдэг тэмдэглэгээ байршуулж, уурхайн ажилчидын хүрээнд сургалт зохион байгуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан	100,000	Үйл ажиллагааны туршид	хамгаалалттай газар нутгийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай,
Үер	Цогцолборын эзэмшил талбайг хаврын шар ус, хур бороо элбэгтэй үед үерт автахаас сэргийлж ус зайлуулах суваг хоолой, даланг технологийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх нь зүйтэй.	Уурхайн хотхон нь өндөрлөг газар байрлах тул шар усны үер болон хур борооны үерт автахгүй болно	-	-	
Үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой ахуйн осол аваар болох	Үйлдвэрийн ажилчдад Хөдөлмөр аюулгүй байдлын талаарх сургалтыг улирал тутамд буюу жилд 2 удаа зохион байгуулах	Үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөр аюулгүй байдлын талаарх сургалтыг улирал тутамд явуулж байсан	400,000	Үйл ажиллагааны хүрээнд жилд 3 удаа	
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Хувцас хэрэгслээр хангаж ажилласан	Хөрөнгө оруулалтын зардалд тусгагдана	Жилд 1 удаа / өвөл, зуны /	
	Үйлдвэрийн ажилчдыг жилд 1 удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт оруулах	Эмнэлгийн үзлэгт Хамруулж байсан	2,000,000	Жилд 1 удаа	
Нийт зардал			2,500,000 сая.төг		

7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйл ажиллагааны явцад гарах ахуйн хог хаягдлыг Заамар сумтай гэрээ байгуулан тээвэрлүүлсэн. /Төлбөр төлсөн баримт хавсаргав/ Мөн байгальд шууд хаягдах хаягдлын хэмжээг багасгахын тулд эх үүсвэр дээр нь ялган ангилалт хийх хогийн савыг уурхайн хотхон байрлуулан, ялган ангилалт хийж, ажилчдад хог хаягдлын хор уршиг болон ялган ангилалтын үр ашгийн талаарх сургалтуудыг орсон.

Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
---	--------------	---------------	---------

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

- | | | |
|---|---------------------------|--|
| 1. Зарим хаягдлыг нэгдсэн журмаар сумын хогийн цэгт хаях | | Засаг даргатай хийсэн гэрээг хавсралт хэсэгт оруулав. |
| 2. Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ. | Компанийн захирал | |
| 3. Хог хаягдлын төлбөрөө төлөх | | Төлбөр төлсөн баримт хавсаргав. |
| 4. Ахуйн шингэн хаягдал гүний усыг бохирдуулж байгаа эсэхэд бохир усны химийн шинжилгээ хийлгэх | | Хяналт шинжилгээний ажлаар гүний худагнаас усны дээж авч шинжилгээнд өгсөн ба шинжилгээний дүнг хавсралтад оруулав.

Хаягдал усны гэрээ, дүгнэлтийг гаргуулсан бөгөөд хаягдал ус зайлуулах зөвшөөрөлтэй. |
| 5. Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдан авах | Байгаль орчны мэргэжилтэн | Ахуйн бохироо Тамир-ЭМ бэлдмэлээр ариутган халдваргүйжүүлэн, задалдаг. |
| 6. Уурхайн техникт ашигласан тос, маслыг хаягдал тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх | | Одоогоор хаягдал тосыг цуглуулах ажил хийгдэж байгаа бөгөөд “Алтан Оршихуй” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээг хавсаргав. |
| 7. Ахуйн хатуу хог хаягдлаа ангилах хогийн савнуудыг байрлуулах | | Уурхайн хотхонд хуванцар сав, шил болон лааз, цаасан хаягдлуудыг ялгах тасалгаа бүхий тагтай сав хаягдал төмөр ашиглан хийж, байрлуулсан. |
| 8. Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялгах | | Ялган ангилаад хурааж байна. |

8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус оны 10 дугаар сард “Ногоон эко мандала” ХХК-аар хийлгүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд хөрс, уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж мөн агаар дахь тоосжилтын хэмжээ болон дуу, чимээ, харьцангуй чийгшил зэрэг үзүүлэлтүүдийн хэмжилтийг хийсэн.

Хяналт шинжилгээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	2022 оны хяналт шинжилгээний хэлбэр, зардал	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	Хяналт шинжилгээ явуулах байршил	Хяналт шинжилгээ хийх багаж, холбогдох стандарт
--------------------------	------------------------------	---	----------------------------------	----------------------------------	---

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, дуу чимээ	Агаарын шинжилгээний 3 цэгт жилд 1 удаа хэмжилт хийлгэнэ. 1 цэгт нэг удаагийн хэмжилт – Нийт 108 000 төг	Жил бүрийн 5 болон 8 дугаар саруудад	Уурхайн карьер, Уурхайн зам, Ажилчдын хотхон	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016
	Ажилчдын унд ахуйд ашигладаг усыг бактериологи болон ундны усны ерөнхий шаардлага, цэврийн болон бохирын нуурын усыг гадаргын ус болон хүнд металлын шинжилгээнд өгөх	Унд ахуйн ус-1 ширхэг Бактериологи - 1 ширхэг Усны химийн ерөнхий шинжилгээ – 1 ширхэг Цэврийн болон бохирын нуур – 1 ширхэг Хүнд металл 1 ширхэг Нийт – 174 800 төгрөг “Монгол Ус” ТӨҮГ	Жил бүрийн 5 болон 8 дугаар саруудад	Унд ахуйн усны гүний 5 худаг, цэврийн болон бохирын нуур	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2018, Байгаль орчны аялал жуучлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А82/128 тоот тушаалын хавсралт. Ахуйн хаягдал ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам
Хөрс	Хөрсний агрохими болон хүнд металлын шинжилгээ	Шимт хөрсний овоолго- 2 ширхэг Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай – 2 ширхэг	Жил бүрийн 5 болон 8 дугаар саруудад	Уурхайн шимт хөрсний овоолго, ахуйн бохир усны хаягдал орчимд,нөхөн сэргээсэн талбай, эвдрээгүй газар	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох
	хийлгэх мөн тухайн газар дээр хөрсний температур хэмжих	Засварын талбай-1 ширхэг Шатахуун түгээх газар -1 ширхэг Нийт 3 ширхэг 107 800 төгрөг			MNS2305-94 Дээж авах. савлах. тээвэрлэх. хадгалах журам MNS(ISO) 4814:1999. Атом Шингээлтийн Спектрметрээр шинжилгээ хийх

**9. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭ**

Аймгийн Засаг даргын албан шаардлага ирээгүй болно.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



Зураг 7 Ажилчдын хотхон, засварын талбайгаас хөрсний дээж авч байна

**10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт 7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх		Байгаль орчны бодлого хөтөлбөр, хяналт шинжилгээ хийх журам, хог хаягдлын цуглуулах, хадгалах ажлын тухай заавар журмуудыг захирлаар батлуулж, ажилчдад танилцуулан дагаж мөрдөн ажиллаж байна.
2.	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтэнгүүдийг газар дээр нь танилцуулна.	Компанийн захирал	Заамар сумын Хайлааст багийн иргэдийн нийтийн хуралд уурхайн үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн талаар илтгэл хэлэлцүүлсэн.
3.	Техник болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг сум орон нутаг болон улсын комисст хүлээлгэн өгөх	Байгаль орчны мэргэжилтэн	Улсын комисст хүлээлгэн өгсөн актыг хавсралтад оруулав.
4.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Заамар сумын ЗДТГ-т хүргэн өгч байх		Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон тус оны нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлагын тайланг хүргэн танилцуулдаг.

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил болон нөлөөлөлд өртөх оршин суугчдад тайлан тавих ажил хийгдэх шаардлагагүй.

12. ДҮГНЭЛТ

2023 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу **0.5 га** талбайд уулын ажил явагдсан. Дотоод овоолгоор олборлолт явуулсан талбайн **2.2 га-д** техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд байсан бол **2.5 га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.

Биологийн нөхөн сэргээлтийг 2023 оноос эхлэн үе шаттайгаар нөхөн сэргээхээр төлөвлөөд байна.

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төслийн талбайд тусгайлан мод үржүүлгийн суулгацын талбай бэлдсэн. Энэ талбайд одоогоор чацаргана 70ш, хайлаас 100ш, улиас 300ш, алим 10ш, голт бор 50ш, бургас 200ш, үхэр нүд 20ш суулгацыг үржүүлж байна.

Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээх ажлын хүрээнд орон нутгаас санал болгосон 15.0 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн.

2022 оны байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг 10 сард байгаль орчны үнэлгээ, зөвөлгөөний эрх бүхий байгууллага “Ногоог эко мандала” ХХК-аар хийлгэн гүйцэтгүүллээ.

Энэхүү хяналт шинжилгээний хүрээнд уурхайн технологийн ус болон цэвэр усны нууранд гадаргын усны чанар стандартад нийцэж байгаа эсэхэд бохирын нуурын усанд хүнд металлын үзүүлэлт, агууламж хэдий хэмжээтэй байгааг итгэмжлэгдсэн лабораториудад дээж өгч шинжлүүлэн өмнөх сарын үр дүнтэй харьцуулж үзсэн. Тус шинжилгээний дүнгээр цэвэр нуурын ус гадаргын усны стандартад шаардлагын түвшинд, бохирын нуурын хүнд металлын агуулга стандартаас хэтрээгүй үзүүлэлттэй байсан.

Уурхайн ундны ундны усны стандартад нийцэж байгаа эсэх, мөн бактерлогийн шинжилгээ хийлгэсэн. Тус шинжилгээний үр дүнд Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2005 стандартын хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт илрээгүй стандартын шаардлага хангаж байгаа фильтертэй усыг унданд хэрэглэх нь илүү зохимжтой.

Уурхайн засварын газар, ШТС-ын ойролцоо газрын хөрсөнд хүнд металлын шинжилгээ хийлгэсэн бөгөөд стандарт түвшинд байна.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хавсралт 1. Ус ашиглах зөвшөөрөл

Хавсралт 2. Гүний худгийн усны дээж шинжилгээ MNS 0900:2018

Хавсралт 3. Технологийн усны дээж шинжилгээний дүн

Хавсралт 4. Ус ашиглах гэрээ

Хавсралт 5. Усны төлбөр төлсөн баримт

Хавсралт 6. Газар ашиглалтын гэрээ

Хавсралт 7. Газрын төлбөр төлсөн баримт

Хавсралт 8. БО нөхөн сэргээлтийн барьцаа 50% төлсөн баримт

Хавсралт 9. Засварын талбай дахь хөрсний дээжний шинжилгээний дүн

Хавсралт 10. Уурхайн хотхон дахь хөрсний дээжний шинжилгээний дүн

Хавсралт 11. Шимт хөрсний дээжний шинжилгээний дүн

Хавсралт 12. Агаарын дээжний шинжилгээний дүн

Хавсралт 13. Хог хаягдлын гэрээ

Хавсралт 14. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт

Хавсралт 15. ТЭЗҮ хүлээж авсан тушаал, дүнгэлт

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хавсралт 1. Ус ашиглах зөвшөөрөл

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



ТУУЛ ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, танай компанийн 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 23/14 дугаартай албан хүсэлт, “Усны газар”-ын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/614 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 116 тоот “Ус ашиглуулах дүгнэлт”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-05092 дугаартай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй “Баян-Овоот уул” алтны шороон ордыг ил аргаар олборлох төслийн 19'780.0 м³ элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэглээнд шаардагдах 35'085.0 м³ усыг Туул голоос, унд ахуйд ашиглах 756.0 м³ усыг “Гурван тамга” ХХК-ийн эзэмшлийн 1 гүний худгаас 2023 онд ашиглахыг “Заамар өгөөмөр хайрхан” ХХК-д зөвшөөрсүгэй.

2. Ус ашиглагчтай гэрээ байгуулах, ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга /П.Энхбаяр/, Туул голын сав газрын захиргааны менежерийн албан үүрэг гүйцэтгэгч /Д.Жаргал/ нарт үүрэг болгосугай.

3. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 30 дугаар зүйлд заасан ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, ус ашиглалтын тайланг 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн дотор Сав газрын захиргаанд ирүүлэхийг “Заамар өгөөмөр хайрхан” ХХК /Ч.Уламбаяр/-д даалгасугай.


МЕНЕЖЕРИЙН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЖАРГАЛ



**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хавсралт 2. Гүний худгийн усны дээж шинжилгээ (MNS 0900:2018)



ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс 77278899, 77288899

E-mail: soil_lab@geo-mongol.mn

**ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



Дугаар: 22/3912

Дээж авсан огноо: 2022 он 10 сарын 26

Шинжилгээ хийсэн огноо: 2022 он 10 сарын 27-28

Дээж авсан газрын нэр: Төв аймаг, Заамар сум, MV-0050928, Баянголын дэнж алтны шороон орд

Координат: -

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Заамар өгөөмөр хайрхан” ХХК

Харилцах утас: 90996660 80108001

Уст цэгийн төрөл ба дугаар: Худаг

Лаб № 22/8483

Усны химийн задлан шинжилгээний дүн

Анион	мг/л	мг/экв	%, мг-экв/л	Катион	мг/л	мг/экв	%, мг-экв/л
Cl ⁻	48.92	1.38	16.54	Na ⁺ +K ⁺	2.91	0.13	1.52
SO ₄ ²⁻	125.60	2.62	31.39	NH ₄ ⁺	0.10	0.01	0.07
NO ₃ ⁻	21.00	0.34	4.07	Ca ²⁺	94.19	4.70	56.41
NO ₂ ⁻	0.01	0.00	0.00	Mg ²⁺	42.56	3.50	42.01
CO ₃ ²⁻	0.00	0.00	0.00	Fe ²⁺	0.00	0.00	0.00
HCO ₃ ⁻	244.08	4.00	48.01	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	439.61	8.33	100.00	Дүн	139.76	8.33	100.00

Анион катионуудын нийлбэр:

579.37 мг/л

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр:

457.0 мг/л

Хуурай үлдэгдэл:

622.0 мг/л

Ерөнхий хатуулаг:

8.20 мг-экв/л

pH:

8.78

Исэлдэх чанар:

0.64 мг/л

Усны физик шинж, чанар

Шүүгдэсний өнгө: Өнгөгүй

Үнэр: Үгүй

Амт: -

Булингар: Тунгалаг

Тунадас: Үгүй

Усны давсны химийн найрлагын томъёо $M(622.0 \text{ мг/л}) = \frac{HCO \ 48.50 \ 31}{Ca \ 56 \ Mg \ 42}$

Тайлбар

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилтгүй, хатуу ус байна.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)

Лабораторийн эрхлэгч:

Л. Цагаандархи /MS.c/

Задлан шинжээч:

О.Алтанцэцэг /MS.c/



**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хавсралт 3. Технологийн усны дээж шинжилгээний дүн



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ

/Central inspection laboratory/

Төв аймаг, Заамар сум, Хайлааст баг, Тунгаах
нуур

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН
СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС**

/Test result of accredited laboratory/



**TL 092
MNS ISO 17025**

Захиалагчийн нэр /Customer name/: "Заамар Өгөөмөр Хайрхан" ХХК

Дээжний дугаар /Test number/	Дээжний хаяг, байршил /Sample location/	Уст цэгийн төрөл /Type of water/	
№ 892	Төв аймаг, Заамар сум, Хайлааст баг, Тунгаах нуур	Бохир ус	48°21'3.81" 104°30'03.6"
Дээжний тоо, хэмжээ /Quantity of the sample/	Дээж хүлээн авсан огноо /Date receipt/	Шинжилсэн огноо /Analyzing date/	Хэвлэсэн огноо /Printed date/
2.5л / 2.5L /	2023.07.03	2023.07.03- 07.18	2023.07.27
Техникийн шаардлага / Technical requirements/ MNS 4943:2015			
Шинжилгээний аргын стандарт /Test method/ MNS ISO 11885:2011 /ICP/			

№	Үзүүлэлт /Parameters/	ЗДХ /Technical specification/ мг/л	Үр дүн /Test result/	№	Үзүүлэлт /Parameters/	ЗДХ /Technical specification/ мг/л	Үр дүн /Test result/
1	Манган, (Mn) мг/л /Manganese, Mn, mg/L /	<0.5	<0.005	11	Хөнгөнцагаан, (Al), мг/л /Aluminum, Al, mg/L /	<0.5	0.0045
2	Никель, (Ni) мг/л /Nickel, Ni, mg/L /	<0.2	0.0035	12	Лити, (Li) мг/л /Lithium, Li, mg/L /	-	0.0046
3	Зэс, (Cu) мг/л /Copper, Cu, mg/L /	<1.0	<0.0042	13	Барий, (Ba) мг/л /Barium, Ba, mg/L /	<1.5	<0.007
4	Кадми, (Cd) мг/л /Cadmium, Cd, mg/L /	<0.03	<0.0015	14	Мөнгө, (Ag) мг/л /Silver, S, mg/L /	-	<0.004
5	Кобальт, (Co) мг/л /Cobalt, Co, mg/L /	<0.02	<0.0054	15	Бор, (B) мг/л /Bor, B, mg/L /	<0.5	0.0012
6	Хар тулгар, Pb мг/л /Lead, Pb, mg/L /	<0.1	<0.0014	16	Галлий, (Ga) мг/л /Gallium, Ga, mg/L /	-	<0.0021
7	Цайр, (Zn) мг/л /Zinc, Zn, mg/L /	<3.0	<0.0098	17	Стронций, (Sr) мг/л /Strontium, Sr, mg/L /	<2.0	0.0003
8	Нийт хром, (Cr) мг/л /Chromium, Cr, mg/L /	<0.3	<0.0043	18	Инди, (In) мг/л /Indium, In, mg/L /	-	<0.004
9	Нийт төмөр, (Fe) мг/л /Iron, Fe, mg/L /	<1.0	0.0013	19	Таллий, (Tl) мг/л /Tallium, Tl, mg/L /	-	<0.0022
10	Бисмут, (Bi) мг/л /Bismuth, Bi, mg/L /	<0.001	<0.0003	20	Ванадий, (V) мг/л /Vanadium, V, mg/L /	<0.1	<0.005

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/:

Химич /Chemist/

Н. Халиунаа /N.Haliunaa N MSc/

Хянасан /Approved/:

Лабораторийн эрхлэгч /Head of laboratory/

Д.Мөнхзул /D.Munkhzul D MSc/

Хуудас 1/1

Энэхүү сорилтын дүн нь тухайн дээжийн хувьд хүчинтэй. /The test result report is applicable to the sample/
Сорилтын лабораторийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлахыг хориглоно. /It is prohibited to reproduce the results without laboratory authorization/

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ
/Central inspection laboratory/

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 хороо,
“Баянгол” уудамс, Утас: 71180075

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН
СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС**
/Test result of accredited laboratory/



TL 092
MNS ISO 17025

Захиалагчийн нэр /Customer name/: “Заамар Өгөөмөр Хайрхан” ХХК

Шинжилгээний тодорхойлолт /Analysis type/	Дээжний дугаар /Sample number/	Дээжний хаяг, байршил /Sample location/	Уст цэгийн төрөл /Type of water/	
Бохир усны хими/микробиологи	№ 891	Төв аймаг, Заамар сум, Хайлааст, баг, Бохирын нуур	Бохир ус	48°21'33.0" 104°29'56.7"

Дээжний хэмжээ /Quantity of sample/	Дээж хүлээн авсан огноо /Receiving date/	Шинжилсэн огноо /Analyzing date/	Хэвлэсэн огноо /Printed date/	Техникийн шаардлага /Technical requirements/
2.5л / 2.5L /	2023.07.03	2023.07.03-07.28	2023.07.29	MNS 4943:2015

№	Үзүүлэлт /Parameters/	Шинжилэх аргын стандарт /Test method/	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /Technical specification/	Үр дүн /Test result/
1	pH-Усны орчин /Hydrogen ions, mg/l /	MNS ISO 10523:2001	6.0-9.0	7.97
2	Аммоний, (NH ⁴⁺) мгN/л /Ammonia, mgN/l/	MNS ISO 1428:1997	-	3.61
3	Хлорид, Cl ⁻ , мг/л /Chloride Cl ⁻ mg/l /	MNS ISO 9297: 2007	-	67.35
4	Сульфат (SO ₄) ²⁻ мг/л / Sulfate, mg/l /	MNS ISO 6271:2011	-	210.66
5	Умбуур бодис, мг/л /TSS, mg/L /	MNS ISO 11923:2001	<30.0	45.00
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, (XXX), мг/л /COD, mg/l /	ХТЛ-CA3-4/02	<50.0	6.20
7	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, (БХХ), мг/л /BOD, mg/l /	ХТЛ-CA3-4/01	<20.0	2.38
8	Нитрит (NO ₂), мгN/л / Nitrite, mgN/l /	MNS ISO 4431:2005	-	0.05
9	Нитрат (NO ₃), мгN/л / Nitrate, mgN/l /	MNS ISO 7890-3:2001	-	1.74
10	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч 1 мл-т	MNS 5668:2006	илрэхгүй	Илрээгүй

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/:

Химич /Chemist/ Н. Халиунаа / N.Haliunaa.N MSc/

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/:

Микробиологич / Microbiologist / Г. Нарансолонго / Naransolongo.G/

Хянасан /Approved/:

Лабораторийн эрхлэгч / Head of laboratory/ Д.Мөнхзул / Munkhzul.D MSc/

Хуудас/ page: 1/1

Сорилтын дүнгийн хуудас нь тухайн сорьцонд хамаарна. /The test result report is applicable to the sample/
Сорилтын лабораторийн зөвшөөсөгчгүйгээс хуулбарлахыг хориглоно. /It is prohibited to reproduce the results without laboratory authorization/

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хавсралт 4. Ус ашиглах гэрээ

БАТЛАВ
МЕНЕЖЕРИЙН АЛБАН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ.


Д.ЖАРГАЛ
2023 оны 06 дугаар сарын 17

БАТЛАВ
“ЗААМАР ӨГӨӨМӨР ХАЙРХАН”
ХХК-ИЙН ЗАХИРАЛ


Ч.УЛАМБАЯР
2023 оны 06 дугаар сарын ...

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар УНТ 23/28

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу “Усны газар”-ын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/614 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 116 тоот “Ус ашиглуулах дүгнэлт”, Туул голын сав газрын захиргааны даргын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/ 35 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга П.Энхбаяр, Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Union building, А блок, 405 тоотод байрлах, Улсын бүртгэлийн 1144006126 дугаартай, 3863689 регистрийн дугаартай “Заамар өгөөмөр хайрхан” ХХК-ийн Геологич С.Цэнгүүн харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /Нэг/ жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. *Ус ашиглах зориулалт:* Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-05092 тусгай зөвшөөрөлтэй “Баян-Овоот уул” алтны шороон ордын үйлдвэрлэл технологийн болон бусад хэрэглээний усыг Туул голоос, унд ахуйн усыг “Гурван тамга” ХХК-ийн эзэмшлийн 1 худгаас ашиглана.

2.1.1. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4.4-т заасны дагуу 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулна.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 19'780.0 м³ элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэглээнд зарцуулах ус 35'841.0 м³/жил;

2.2.1. Унд, ахуйн хэрэгцээнд ашиглах газрын доорх ус: 756.0 м³/жил;

2.2.2. Ашигт малтмал олборлох, баяжуулахад ашиглах гадаргын ус: 32'000.0 м³/жил;

2.2.3. Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах гадаргын ус: 1'420.0 м³/жил;

2.2.4. Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах гадаргын ус: 1'665.0 м³/жил;

2.3. *Усны чанар, найрлага:* 2023 оны 06, 09, 11 дүгээр сард хаягдлын нуурын уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. *Усны эх үүсвэр:*

2.4.1. *Байршил:* Унд ахуйн усыг “Гурван тамга” ХХК-ийн эзэмшлийн 1 худгаас, технологийн болон бусад хэрэглээний усыг Туул голоос хангана. Худгийн байршлын солбицол 48°18'51.0", 104°33'58.0".

2.4.2. *Барилга байгууламж*: Туул голоос ус татах төмөр хоолойн урт 250.0 м, голч 219 мм хоолойгоор ус татна. Цэвэр усан сангийн эзэлхүүн 40'000.0 м³, тунаах сангийн эзлэхүүн 19'000.0 м³.

2.4.3. *Тоног төхөөрөмжийн нэр, марк*: Уурхайн олборлолтод CATERPILLAR CAT349EL маркийн экскаватор 1 ш, CATERPILLAR CAT329 маркийн экскаватор 1 ш, SHUNTUI SD13 маркийн бульдозер 1 ш, KOMATSU WA430 маркийн утгуурт ачигч, HOWO маркийн автосамосвал 4 ш, Баяжуулах боловсруулах үйлдвэрт Геомаш-40 маркийн хүрдэт шигшүүр 1 ш, Гравитацийн сэгсрэх ширээ 1 ш, Д-320 маркийн динамик насос 1 ш, Д-321 маркийн динамик насос 1 ш тус тус ашиглана.

2.4.4. *Насосны хүчин чадал*: Д-320 маркийн насосоор усан сан руу, усан сангаас угаах төхөөрөмжийн шугамд Д-320 маркийн насосууд суурилуулсан.

2.5. *Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага*: Хаягдал усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартын шаардлагыг мөрдлөг болгоно. Стандартаас давсан агууламжтай хаягдал усыг байгальд нийлүүлж буй тохиолдолд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу төлбөр тооцно.

2.6. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин*:

2.6.1. Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана. Стандартаас давсан агууламжтай хаягдал усанд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу төлбөр тооцно.

2.6.2. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2018 оны А/82/128 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам”-ын дагуу тохижуулж ашиглана.

2.7. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ*:

2.7.1. Туул голоос ус татах насосыг байрлуулахдаа голын эрэг, голдирлыг хөндөхгүйгээр байрлуулна.

2.7.2. Усны эх үүсвэрийг хамгаалах усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлж жил бүр түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төсөвт суулган орон нутгийн захиргаа, байгаль хамгаалагчаас санал авч сэргээн засварлах шаардлагатай булаг шандыг тохижуулах;

2.7.3. Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 1.5 га талбайд, “Тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд 500.0 ш мод тарина.

2.8. *Усны тоолуур*: Усны тухай хуулийн 30.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж, Туул голоос ус татаж буй насосны гаралт дээр тоолуур суурилуулна. Тоолуурын заалтын тэмдэглэлийг тогтмол хөтлөж, баталгаажуулна.

2.9. *Ус ашигласны төлбөрийн хэмжээ*:

2.9.1. Ашигт малтмал олборлон, баяжуулахад ашиглах 32'000.0 м³ гадаргын усны төлбөр 19'087'200.0 /Арван есөн сая наян долоон мянга хоёр зуун/ төгрөг, зам талбайн тоосжилт дарахад ашиглах 1'420.0 м³ гадаргын усны төлбөр 112'933.0 /Нэг зуун арван хоёр мянга есөн зуун гучин гурван/ төгрөг, биологийн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах 1'665.0 м³ гадаргын ус ашигласны төлбөрт 30'897.4 /Гучин мянга найман зуун ерэн долоон/ төгрөг, нийт **19'231'030.0 /Арван есөн сая хоёр зуун гучин нэгэн мянга гучин/** төгрөгийг Төв аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 60 хувийг гуравдугаар, 40 хувийг дөрөвдүгээр улиралд төлнө.

2.9.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор төлж барагдуулна.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3

2.9.3. Гэрээнд зааснаас хэтрүүлэн ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-д заасны дагуу төлбөр тооцно.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.6, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүдгээр зүйлийн 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.3. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцоор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж буй усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Туул голын сав газрын захиргааны менежер

...../Д.ЖАРГАЛ/

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга

...../П.ЭНХБАЯР/

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны мэргэжилтэн

...../Н.БОЛОР-ЭРДЭНЭ/

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД, 2-р хороо, Чингүнжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр, 203 тоот.

Харилцах утас: (976) 70003714.

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ЗААМАР ӨГӨӨМӨР ХАЙРХАН” ХХК-ийн Геологич

...../С.Цэнгүүн/
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Union building, А блок, 405 тоот.

Харилцах утас: (976) 94070001.

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хасвралт 5. Усны төлбөр төлсөн баримт

ХААН БАНК

Огноо/Date: 2023-06-06 08:56:23

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын /Journal No: 2829924

Системийн огноо/System Date: 2023-06-06

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number 5447006666	Нэр/Name СҮЛД-ЭРДЭНЭ ЦЭНГҮҮН	Дүн/Amount 4,397,000.00 MNT	Ханш/Rate 1.00
Кт	Банкны дугаар/Branch No MOPUMNUS IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number MN350090 100140000944	Банкны нэр/Bank Name ТӨРИЙН САН Нэр/Name Тө.Ус ашигласны төлбөр	4,397,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
ЗААМАР ӨГӨӨМӨР ХАЙРХАН УС АШИГЛАСНЫ Т

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Овог, нэр/Fullname: Рэнцэнбат овогтой Мөнхтуяа / Munkhtuya Rentsenbat
Албан тушаал/Position: Гүйцэтгэх захирал / Chief executive officer
Баталгаажуулах код/Verification code:
BP53CNC8U7ZUJ77K
Уг баримт бичиг нь Монгол Улсын "Цахим гарын үсгийн тухай" хуулийн 8.1 дугаар заалтын дагуу тамгыг орлох чадвартай тоон гарын үсгээр баталгаажсан болно.
This document is verified by a digital signature that can replace an official stamp under the 8.1st clause of Mongolian Law on Digital Signatures.
Та <https://verify.khanbank.com/> вебсайт руу хандан дээрх 16 орон бүхий кодыг оруулснаар мэдээллийг шалгах боломжтой. Мөн уг холбоосоор дамжин цахим тоон гарын үсгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.
You can verify this document by going to <https://verify.khanbank.com/> and entering the 16-digit verification code provided. You can also find more information about digital signature on this page.

Санамж: Бага дүнтэй (Таван сая төгрөг хүртэлх дүнтэй) гүйлгээ тухайн данс руу шууд шилжих бөгөөд таван сая төгрөгөөс дээш дүнтэй үед хүлээн авагчийн нэр, данс зөрвөл таны данс руу буцан орно. Амжилттай гүйлгээний баримт таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээгдэнэ. Ажлын өдрийн 16:00 цагаас хойш болон амралтын өдөр таарсан их дүнтэй (таван сая төгрөгөөс дээш дүнтэй) гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэхийг анхаарна уу.

ГАНХИЙСЭГ ЗААЛААР
ГАТАХ ААЖУУЛА

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хавсралт 6. Газар ашиглалтын гэрээ



Нэгж талбарын дугаар: **4127041921**
Улсын бүртгэлийн дугаар: **Э-1415000086**
Гэрчилгээний дугаар: **0000055758**

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР
ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 10 сарын 26 өдөр

№ 04152-2022/00015

Төв аймаг/хот Заамар сум/дүүрэг

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Төв аймаг /нийслэл/-ийн Заамар дүүрэг /сум/-ын Засаг даргын 2022 оны 03 сарын 25-ны өдрийн 04152-47/2022 тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж, Төв аймаг/хотын Заамар сум/дүүргийн Газрын алба, газар эзэмшигчийг төлөөлж Заамар Өгөөмөр хайрхан-ны Захирал Чалхаа овогтой Уламбаяр нар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ

371619 м2

Үүнээс:

**Нэгж талбарын тодорхой
хэсгийг эзэмших зориулалт**
Уурхайн газар

**Тухайн зориулалтаар
эзэмших газрын хэмжээ**
371619 м2

**Газар эзэмших
хугацаа**
15 жил

2.2. Газар эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн хуульд заасны дагуу газрын төлбөрийг тооцож ногдуулна.

2.3. Газрын төлбөрийг нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар эзэмших, ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

Гурав. Газар эзэмшигчийн эрх

3.1. Гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;

3.2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3.3. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

3.4. Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;

3.5. Газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.

3.6. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах /Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах/;

3.7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Дөрөв. Газар эзэмшигчийн үүрэг

- 4.1. Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;
- 4.2. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;
- 4.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх/ 5 жилд нэг удаа хийлгэнэ./;
- 4.4. Бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- 4.5. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хуульд заасан хугацаанд нь төлөх;
- 4.6. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
- 4.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;
- 4.8. Газар эзэмшүүлэгчээс газрын эзэмшил ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
- 4.9. Кадастрын зураглал гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах
- 4.10. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах
- 4.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх
- 4.12. Эдлэн газрын эргэлтийн цэгүүдийг хөдөлгөсөн, нүүлгэн шилжүүлсэн, устгахгүй байх
- 4.13. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.
- 4.14. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх
- 4.15. Барилга байгууламжийн төлөвлөлтийн эскиз зургийг сум болон аймгийн ерөнхий архитектороор батлуулах
- 4.16. Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.
- 4.17. Барилгын улаан шугам тавихад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнг оролцуулан баталгаажуулах
- 4.18. Гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг заасан хугацаанд арилгах арга хэмжээ авах
- 4.19. Эзэмшил, ашиглалтанд байгаа болон орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид тохижилт, арилчилгаа хийх
- 4.20. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Тав. Газар эзэмшүүлэгчийн үүрэг

- 5.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;
- 5.2. Уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараахь шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй. Үүнд:
 - а. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх
 - б. Эзэмшүүлэхээр олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулахгүй байх
 - в. Газрыг зориулалтын дагуу эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

г. Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.

д. Барилгын зургийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ба барилгыг мэргэжлийн байцаагчаар хянуулах

е. Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах

5.3. Газрыг гэрээний нөхцөлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу Газрын тухай хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тухайлбал:

а. Эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

б. Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

в. Шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

г. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй;

эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

е. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр* гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй* зэрэг тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

ё. Өмнөх гэрээний биелэлтээр илэрсэн зөрчлийг арилгуулах

5.4. Газар эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх;

5.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Зургаа. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

6.1. Газар эзэмшигчийн эзэмшилд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл газар эзэмших эрх мөн адил шилжих болно гэж шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү гэрээгээр эзэмших газрыг хязгаартай эзэмших эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь газрын тухай хуулийн 48-р зүйлд заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

6.3. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

6.4. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: Эзэмших эрх бүхий газраа зориулалтын дагуу эзэмшээгүй болон газрын төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулаагүй тохиолдолд газар эзэмших эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

Жич: “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр...” гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно.

“... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй” гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно.

Долоо. Бусад зүйл

7.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

7.2. Газар эзэмшүүлэх гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар эзэмшигч гэрээний биелэлтийг жил бүрийн 06-р сарын 25-ны дотор багтаан тайлагнаж, газар эзэмшүүлэгч 07-р сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.

7.3. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлээгүй, өмнөх гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

7.4. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.5. Газар олгох техникийн нөхцөл болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийн дагуу тухайн газар дээр байрлаж буй инженерийн шугам сүлжээг холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр нүүлгэн шилжүүлэх ба түүнтэй холбогдон гарах зардлыг газар эзэмших эрх авсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар эзэмшүүлэгч;

Утас:

Газар эзэмшигч: **Заамар Өгөөмөр хайрхан**
Газрын байршил: **Төв Заамар 3-р баг Хайлааст Баян овоот уул**
Газар эзэмшигчийн хаяг: **Төв Заамар 3-р баг**
Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: **/3863689/**
Банк, дансны дугаар: ,
Харилцах утас:

Газар эзэмшигч **Заамар Өгөөмөр хайрхан** нь гэрээний нөцөлийг Газрын нэгдмэл сангийн удирлагын цахим систем [/www.egazar.gov.mn/](http://www.egazar.gov.mn)-д **2022-08-24 16:18:29** цагт зөвшөөрч, баталгаажуулав.

Энэхүү гэрээний нэг хувийг **4127041921** дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хавсралт 8. БО нөхөн сэргээлтийн барьцаа 50% төлсөн баримт



ХААН БАНК

Огноо/Date: 2023.06.15 15:55:18

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000475762439

Системийн огноо/System Date: 2023.06.15 15:55:10

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5447006666	С*****Э ЦЭНГҮҮН	5,000,000.00 MNT	1.00
/ Таван сая төгрөг/				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name Төрийн Сан		
	90			
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	100900013406	БО нөхөн сэргээх баталгаа	5,000,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-3863689 Заамар өгөөмөр хайрхан БОНС барьцаа 50 хувь

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

____ Он/Year (YYYY) ____ Сар/Month (MM) ____ Өдөр/Day (DD)

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хавсралт 10. Уурхайн хотхон дахь хөрсний дээжний шинжилгээний дүн



Чанар Хүрд Дэвшил

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 р хороо, Богд Жавзандамба гудамж 34/6 тоот, Хан Рашан компанийн байр

Утас 70109968, 99995316

http://www.khanlab.mn

ХАНЛАБ ХХК




ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА № 2023/1083-4

ЗАХИАЛАГЧИЙН НЭР:

ДЭЭЖЛЭЛТ ХИЙСЭН ГАЗАР: Төв аймаг, Заамар сум, Заамар Өгөөмөр Хайрхан ХХК

БАЙГАЛЬ ОРЧНЫ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО

Хөрс, 2

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	МОНИТОРИНГИЙН ЦЭГ	СОЛБИЦОЛ		Өндөршил, метр	ЭЛЕМЕНТ, %					ЭЛЕМЕНТ, мг/кг				
				Уртлаг	Өргөрөг		Ca	Mg	Na	K	Fe _{сумт}	As	Ba*	Be	Bi	Cd
1	Л-13104	S-391	Кемп	104°30'14.9"	48°21'38.4"	937	2.96	1.47	1.69	2.08	3.92	13.03	542.1	2.02	<10.0	<1.0
2	Л-13105	S-392	Томрийн хаягдал	104°30'18.2"	48°21'38.4"	945	3.38	1.46	1.79	2.20	3.26	15.48	525.2	1.99	<10.0	<1.0

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	МОНИТОРИНГИЙН ЦЭГ	СОЛБИЦОЛ		Өндөршил, метр	ЭЛЕМЕНТ, мг/кг									
				Уртлаг	Өргөрөг		Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb
1	Л-13104	S-391	Кемп	104°30'14.9"	48°21'38.4"	937	17.55	75.00	28.14	38.01	31.99	770.5	<5.0	33.78	778.9	13.72
2	Л-13105	S-392	Томрийн хаягдал	104°30'18.2"	48°21'38.4"	945	13.38	67.24	24.22	32.03	29.86	463.0	<5.0	27.11	638.8	11.04

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	МОНИТОРИНГИЙН ЦЭГ	СОЛБИЦОЛ		Өндөршил, метр	ЭЛЕМЕНТ, мг/кг							
				Уртлаг	Өргөрөг		Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*
1	Л-13104	S-391	Кемп	104°30'14.9"	48°21'38.4"	937	<10.0	<5.0	278.7	4808	100.0	28.83	83.09	93.87
2	Л-13105	S-392	Томрийн хаягдал	104°30'18.2"	48°21'38.4"	945	<10.0	<5.0	262.8	4025	83.55	24.56	63.60	90.32

MNS5850:2019

- 10.00 800.0 - 150.0 - 300.0

Тайлбар: *Бүрэн задраггүй /Хягас тоон утга/

УЛААНБААТАР

ХӨРӨН

ТӨВ

ХАНЛАБ ХХК

2023.09.27

2-1

Хавсралт 11. Шимт хөрсний дээжний шинжилгээний дүн

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашдан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: МБ 2023/196-25

ДЭЭЖИЙН
ТӨРӨЛ, ТОО: Хөрө, 3

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: БАЙГАЛЬ ОРЧНЫ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

ДЭЭЖЛЭЛТ ХИЙСЭН ГАЗАР: ТӨВ АЙМАГ, ЗААМАР СУМ, ЗААМАР ӨГӨӨМӨР ХАЙРХАН ХХК

№	Лаб №	Дээжийн дугаар	Мониторингийн цэг	СОЛБИЦОЛ			ҮЗҮҮЛЭЛТ				
				Уртраг	Өргөрөг	Өндөршил, метр	Дээжийн хэмжээ /г/	Бактерийн френзий тоо	Халуулд тэсвэртэй гэдэсний бүлгийн нэгжийн танин	Кластридיום перфрингенсиийн танин	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч ян
1	Л-704	S-393	Энгийн хот хаягдал	104°30'11.1"	48°21'38.9"	937	300	1.75*10 ³	илрээгүй	илрэв (0.01)	илрээгүй
2	Л-705	S-394	Нүхэн жорлон	104°30'11.0"	48°21'38.5"	945	305	1.15*10 ³	илрээгүй	илрэв (0.0001)	илрээгүй
3	Л-706	S-395	Нүхэн жорлон	104°30'11.1"	48°21'38.7"	942	450	1.72*10 ³	илрэв (0.00001)	илрэв (0.0001)	илрээгүй
ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТ							MNS 6341:2012	MNS 5367:2004	MNS 6341:2012	MNS 6341:2012	
ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ /MNS 3297:1991/								илрэхгүй 1г-а	илрэхгүй 1г-а	илрэхгүй 25г-а	
Чанарын менежер							Д.Түрэвжаргал				

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжийн талаарх. Дээжлэлийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцажгүй болно.

ХҮҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2023.07.17

ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2023.07.19

ШИНЖИЛГЭЭ ДУУССАН ОГНОО: 2023.07.31

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдсэн.

ХУУДАСНЫ ТОО: 1

Хамтран ажигласан танид талархсана.

Хуудас 1-1

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	МОНИТОРИНГИЙН ЦЭГ	СОЛБИЦОЛ		Өндөршил, метр	ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ								
				Уртраг	Өргөрөг		pH	ЕС, mS/cm	Үзүүлэлт, %			Үзүүлэлт, мг-экв/100г		Үзүүлэлт, мг/100г	
									TDS	Ялзмаг	CaCO ₃	Ca ²⁺	Mg ²⁺	K ₂ O	P ₂ O ₅
Тодорхойлах доод хязгаар							1.0	0.005	0.001	0.10	0.10	1.09	0.50	0.50	0.50
1	Л-13104	8-91	Кемп	104°30'14.9"	48°21'38.4"	937	8.59	0.21	0.011	0.46	4.21	13.12	6.25	13.72	6.73
2	Л-13105	8-92	Төмрийн хаягдал	104°30'18.2"	48°21'38.4"	945	8.74	0.43	0.014	0.49	4.00	9.37	13.75	20.16	7.89

3. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	МОНИТОРИНГИЙН ЦЭГ	СОЛБИЦОЛ		Өндөршил, метр	ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН, %							
				Уртраг	Өргөрөг		1-0.25мм	0.25-0.05мм	0.05-0.01мм	0.01-0.005мм	0.005-0.001мм	<0.001мм	<0.01мм	
1	Л-13104	8-91	Кемп	104°30'14.9"	48°21'38.4"	937	11.60	54.12	17.48	8.04	4.88	3.88	16.80	
2	Л-13105	8-92	Төмрийн хаягдал	104°30'18.2"	48°21'38.4"	945	25.35	37.20	17.44	6.96	8.84	4.21	20.01	

Чанарын менежер:

Д. Пүрэвжаргал

Тайлбар: Шинжилгээнд оруулсан дээжнийг 3 сар үргэлж хуучныг ашиглахгүй.

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжнийг хамарна. Дээжлэхгүйн талаарх асуудлыг мөнх лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2023.07.17

ШИНЖИЛСЭН ОГНОО: 2023.09.03


ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгэсэн.

ХУУДАСНЫ ТОО: 2

Хуучин 2-2

Хавсралт 12. Агаарын дээжний шинжилгээний дүн

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2022/A-332
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Заамар Өгөөмөр Хайрхан” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхишиг агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл	: 3 агаар, 3 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2022.09.30
Дээжийн тодорхойлолт	: Төв аймаг Заамар сум Баянголын дэнжийн Алтны шороон орд MV-005092
Шинжилгээний аргын стандарт	: MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021 CA3 A07-2016
Шинжилсэн огноо	: 2022.10.12
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м³	Азотын давхар исэл мг/м³	Нийт Тоос /TSP/ мг/м³	Дуу чимээ /дБА/
1	Уурхай	IX/30	17:15	0.020	0.027	0.114	75
2	Уурхайн технологийн зам	IX/30	18:10	0.017	0.025	0.121	70
3	Хотхон	IX/30	18:50	0.014	0.020	0.075	55
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:
Агаарын хэсгийн инженер



Э.Оюунтуяа

Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хавсралт 13. Хог хаягдлын гэрээ


ЗАСАГ ДАРГА БАТЛАВ
БАТЛАВ
ЖАМГАЛАНБАЯР
Хог хаягдлын гэрээ
2023 оны 06-р сарын 30 -ны өдөр

Дугаар 23

Гэрээний зорилго :

Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөлөлийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах эргүүлэн ашиглах, устгах зорилготой.

Гэрээний эрх зүйн үндэслэл :

- Монгол Улсын хог хаягдлын тухай хууль
- Монгол Улсын Ариун цэврийн тухай хууль

Гэрээ байгуулагч талууд :

Нэг талаас Төв аймгийн Заамар сумын ЗДТГ-ыг төлөөлж Байгаль орчны хяналтын улсын байцаагч Г.Ган-Очир, нөгөө талаас “Заамар Өгөөмөр хайрхан” ХХК-ийн менежер Б.Жамбалсүрэн нар 2023 оны 06 дугаар сарын 30-с 2023 оны 12-р сарын 31-ийг хүртэлх хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ААН байгууллагын эрх үүрэг

1. Монгол Улсын “Хог хаягдлын тухай хуулийн 19, 20-р зүйлийн заалт, Заамар сумын ИТХ-ын 2021 оны 11-р сарын 19-ны өдрийн 01 дугаартай тогтоолыг үндэслэн хог хаягдал гаргасаны төлбөрт жилд 1.000.000 /Нэг сая/ төгрөгийг хог хаягдлын үйлчилгээний санд буюу /Төрийн сан банк/-ны 100141300947 тоот дансанд шилжүүлж байна.
2. ААН, байгууллага, нөхөрлөл өөрийн ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэх, тээвэрлэх, хог хаягдлын талаархи дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байх.
3. Аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж, эсхүл тогтоосон цэгт зөөн тээвэрлэх буюу булшлах.
4. ААН, байгууллага, нөхөрлөл, үйлдвэр, үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ түүний тухай мэдээллийг сумын ЗДТГ-т үнэн зөв мэдээлж байх.
5. Хог хаягдлын ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтандаа эзэмшүүлж аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ХОЁР.Сумын ЗДТГ-н эрх үүрэг

1. Монгол Улсын хог хаягдалын тухай хуулийн 20 дугаар зүйлийг үндэслэн ААН, нөхөрлөл, байгууллагаас хог хаягдал гаргасан төлбөр нэхэмжилж авна.

2. Хуулиар олгосон эрхийн дагуу ААН, байгууллага өөрийн Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдалын хэмжээ түүний талаар өгч буй мэдээлэл, орчны ариун цэврийн байдалд хяналт тавьж шаардлага тавих эрхтэй.

3. Хог хаягдалыг ил асгах, орчин тойрныг бохирдуулах, ариун цэврийн шаардлага хангаагүй нөхцөлд эрүүгийн харицлага хүлээлгэхээргүй бол “Зөрчлийн тухай” хуулийн дагуу хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Гурав.Бусад

1. Монгол улсын хог хаягдалын тухай хуульд өөрчлөлт орсон тохиолдолд төлбөрийн хэмжээг харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

Гэрээ байгуулсан:

Төв аймаг Заамар сумын
БОХУ-ын байцаагч

 Г.Ган-Очир

“Заамар Өгөөмөр хайрхан” ХХК-ийн менежер

 Б.Жамбалсүрэн

Хавсралт 14. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт

 ХААН БАНК Online Date: 2023-09-05 14:41:40

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын дараах №: 23121913
Гүйлгээний дугаар Post: 0

Системийн өгнөө System Date: 2023-09-05

Дт	IBAN/Дансны/Картын дугаар (IBAN/Account/Card number)	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5429282969	НОЁН ГАНЗОРИГ БАТДЭМБЭРЭЛ	1,000,000.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No: MOFUMNUB IBAN/Дансны/Картын дугаар (IBAN/Account/Card Number) 100141300947	Банкны нэр/Block Name: ТӨРИЙН САН Нэр/Name: Тө.За Хог хаягдлын хураамж	1,000,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
заамар өгөөмөр хайрхан ххк

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers



Овог, нэр/Fullname: Рэнцэнбат овогтой Мөнхтуяа / Munkhtuya Rentsenbat
Албан тушаал/Position: Гүйцэтгэх захирал / Chief executive officer
Баталгаажуулах код/Verification code:
XUZ0045JAJRHAQOW

Уг баримт бичиг нь Монгол Улсын "Цахим гарын үсгийн тухай" хуулийн 8.1 дугаар заалтын дагуу тамгыг орнох чадамжтай тоон гарын үсгээр баталгаажсан болно.
This document is verified by a digital signature that can replace an official stamp under the 8.1st clause of Mongolian Law on Digital Signatures.

Та <https://verify.khanbank.com/> вебсайт руу хандан дээрх 16 орон бүхий кодыг оруулснаар мэдээллийг шалгах боломжтой. Мөн уг холбоосоор дамжин цахим тоон гарын үсгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.
You can verify this document by going to <https://verify.khanbank.com/> and entering the 16-digit verification code provided. You can also find more information about digital signature on this page.

Санамж: Бага дүнтэй (Таван сая төгрөг хүртэлх дүнтэй) гүйлгээ тухайн данс руу шууд шилжих бөгөөд таван сая төгрөгөөс дээш дүнтэй үед хүлээн авагчийн нэр, данс зөрвөл таны данс руу буцан орно. Амжилттай гүйлгээний баримт таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээгдэнэ. Ажлын өдрийн 16:00 цагаас хойш болон амралтын өдөр таарсан их дүнтэй (таван сая төгрөгөөс дээш дүнтэй) гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэхийг анхаарна уу

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хавсралт 15. ТЭЗҮ хүлээж авсан тушаал, дүгнэлт


**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТӨСНӨ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 07 сарын 29 өдөр Дугаар 7190 Улаанбаатар хот

**Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Т/21-12-04 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Заамар сумын нутагт орших Заамар өгөөмөр хайрхан ХХК-ийн MV-005092 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баян-Овоот уул талбайн дэнжийн хэсэг буюу Баянголын дэнжийн дээд хэсгийн (ХШ722А – ХШ723) алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанд тооцсугай.
2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.
3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллах, техник-эдийн засгийн үндэслэлийг, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт тус байгууллагын архивд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.
4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.
5. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-005092 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баян-Овоот уул талбайн дэнжийн хэсэг буюу Баянголын дэнжийн дээд хэсгийн (ХШ722А – ХШ723) ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд, Уул уурхай, судалгааны хэлтэст тус тус хүлээлгэн өгөхийг Заамар өгөөмөр хайрхан ХХК-д даалгасугай.

ДАРГА  Х.ХЭРЛЭН

53710972

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2021 оны 09 дугаар сарын 08

№ Т/21-12-04

Улаанбаатар хот

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-005092 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баян-Овоот уул талбайн дэнжийн хэсэг буюу Баянголын дэнжийн дээд хэсгийн (ХШ 722А-723) алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн тухай

“Заамар өгөөмөр хайрхан” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Диамонд повдер” ХХК боловсруулсан Төв аймгийн Заамар сумын нутагт орших Баян-Овоот уул талбайн дэнжийн хэсэг буюу Баянголын дэнжийн дээд хэсгийн (ХШ 722А-723) алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлд Монгол Улсын зөвлөх инженер С.Алтанхуяг зөвлөж, Монгол Улсын зөвлөх инженер Д.Галсандорж шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Техник-эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

2. Техник-эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

3. Техник-эдийн засгийн үндэслэл нь Ерөнхий мэдээлэл, Ил уурхайн олборлолт, Баяжуулах технологи, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, Уурхайн эдийн засаг, төсөв санхүү гэсэн 7 бүлэг, дүгнэлт, хавсралт материал бүхий 102 хуудас тайлбар бичиг, 12 хавсралт зургуудаас бүрдэж байна.

4. Баян-Овоот уул талбайн дэнжийн хэсэг буюу Баянголын дэнжийн дээд хэсгийн (ХШ 722А-723) алтны шороон ордын MV-005092 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

хурлын ХХ-02-01 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан, Үндэсний геологийн албаны даргын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн н-50 тоот тушаалаар бодитой (В) зэргээр 27.7 мян.м³ элс, металл химийн цэврээр 8.9 кг, боломжтой (С) зэргээр 8.6 мян.м³ элс, металл химийн цэврээр 2.3 кг, бодитой болон боломжтой (В+С) зэргээр 36.3 мян.м³ элс, металл химийн цэврээр 11.2 кг гэж улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

5. Төсөлд ашиглалтын үеийн бохирдол 9.14 % (3.32 мян.м³), хаягдалгүй ашиглахаар тооцсон ба ордыг 1 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд нийт 474.07 мян.м³ хөрс хуулж, магадалсан В зэргээр үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 33.68 мян.м³ элс, металл химийн цэврээр 9.32 кг олборлохоор төлөвлөсөн байна.

6. Уурхайн ашиглалтын систем нь авто тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ил уурхайн ашиглалтын системээр ашиглахаар төлөвлөжээ.

7. Ил уурхайн хөрс хуулалт, элс олборлолтын ажилд 3.5 м³ утгуурын багтаамжтай CAT 349E L маркийн экскаватор 1 ширхэг, 2 м³ утгуурын багтаамжтай CAT329 маркийн экскаватор 1 ширхэг, 50 тн даацтай Sinotruk HOWO маркийн автосамосвал 3 ширхэг, 20 тн даацтай Sinotruk HOWO маркийн автосамосвал 1 ширхэг, хөрсний овоолго түрэх ажилд Shantui-SD16 маркийн бульдозер 1 ширхэг зэрэг тоног төхөөрөмжүүдийг үндсэн процессуудад ашиглахаар сонгон тооцоолжээ.

8. Баяжуулах үйлдвэрийн баяжуулах технологийг “Заамар өгөөмөр хайрхан” ХХК-с өгсөн техникийн даалгавар болон “Висмутин” ХХК-ийн лабораторийн туршилтын үр дүнд үндэслэн сонгосон байна. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал 33.68 мян.м³/жил байна. Уг ордын алт агуулсан элсийг гравитацийн аргаар угаан баяжуулж алтны баяжмалын гарц 0.0001 %, 91.8 %-ийн металл авалттай 8.2 кг алт гаргахаар тооцсон байна.

9. Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг Төв аймгийн Заамар сумаас ордын дэргэдүүр өнгөрөх 6 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаас татаж 250 кВт хүчин чадалтай 1 ш бууруулах дэд станц барин цахилгаан эрчим хүчээр хангахаар төсөлд тусгажээ. Ил уурхайн баяжуулах технологийн ажилд жилд 33.1 мян.м³, ажиллагсдын унд ахуйн хэрэгцээнд 1.26 мян.м³, бусад хэрэгцээнд 30.0 мян.м³ ус хэрэглэхээр төлөвлөжээ. Энэхүү усан хангамжийн хэрэгцээний баяжуулах үйлдвэрийн технологийн усны хэрэгцээг уурхайгаас 1 км зайд орших 2 ширхэг хиймэл нуураас (8.53 л/сек), унд ахуйн хэрэглээний усыг 1 ширхэг гүний худгаас (3.5 л/сек) хангахаар тооцоолжээ.

10. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 177.37 сая төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 5.0 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 69.66 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 34.5 сая төгрөг, мониторингийн зардалд 10.31 сая төгрөг, нийгмийн хариуцлагын хүрээнд 15.5 сая төгрөг, бусад ажилд 42.4 сая төгрөг тус тус зарцуулахаар төсөлд тусгажээ.

11. Уг төслийг хэрэгжүүлснээр 31 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1066.32 мян.төг байхаар байна.

12. Төсөл хэрэгжүүлэхэд нийт 433.31 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс биет бус хөрөнгө оруулалт 73.55 сая төгрөг, ил уурхай ба баяжуулах үйлдвэрийн үндсэн техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 243.08 сая төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 116.68 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардалд 104.39 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

13. Уурхайг ашиглах хугацаанд нийт 1.29 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 1.44 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 144.07 сая төгрөгийн татварын өмнөх

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 129.66 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 281.72 сая төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд нэгж бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг 151.6 сая төг/кг байна.

14.Төсөл хэрэгжих хугацаанд нийт 234.05 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 78.48 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 29.92 %, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 3.3 сар байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөл захиалагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/205 тоот тушаалаар баталсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын дагуу үйл ажиллагаа явуулахыг анхааруулж байна.
2. Төсөл захиалагчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийхийг үүрэг болгож байна.
3. Төсөл хэрэгжүүлэгч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын дагуу ашиглалтын үйл ажиллагааг явуулж, олборлосон алтаа Монгол улсын төв банк Монгол банкинд “Заамар өгөөмөр хайрхан” ХХК-ийн нэр дээр тушааж байхыг анхааруулж байна.
4. Төсөлд шаардлагатай мэргэжлээр орон нутгийн иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.
5. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг ЭБМЗ-өөс даалгаж байна.
6. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн “Диамонд повдер” ХХК мөн ТЭЗҮ-ийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын зөвлөх инженер Д.Галсандорж тус тус хариуцна.



**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-005092 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баян-Овоот уул талбайн дэнжийн хэсэг буюу Баянголын дэнжийн дээд хэсгийн (ХШ 722а-723) алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах;
2. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг нь зүйтэй төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-005092 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баян-Овоот уул талбайн дэнжийн хэсэг буюу Баянголын дэнжийн дээд хэсгийн (ХШ 722а-723) алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МӨНХЗОРИГ